



БАРУУН НАРАН ТӨСӨЛ

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНХОНГОР СУМЫН “БАРУУН НАРАН” ОРДОД MV-014493 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР : **MV-014493**
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР : **2887134**

Хянасан:

БОАЖЯ-ны ХБОБНУГ-ын

ахлах шинжээч _____ Ц. Жаргалнэмэх

Хэрэгжилтийг гаргасан:

Хэрэгжилтийг гаргасан:

Үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлөгч _____ С. Лхагва-Очир

“Энержи ресурс” ХХК-ийн

Байгаль орчны ахлах менежер _____ П. Батболд

2022 ОН

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
2. ТӨСЛИЙН ҮНДСЭН БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
3. БАРУУН НАРАН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН	6
4. СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	8
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	15
6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	18
7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	21
8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	22
9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	22
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	25
11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	30
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	35
13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	43
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТӨСВИЙН ЗАДАРГАА.....	45

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Баруун нарангийн чулуун нүүрсний орд нь Өмнөговь аймгийн Ханхонгор, Цогтцэций сумдын нутагт аймгийн төв Даланзадгад хотоос зүүн зүгт 61 км, нийслэл Улаанбаатар хотоос өмнө зүгт 550 орчим км зайнд оршдог ба 4485.64 га талбайд ашигт малтмал ашиглах MV-014493 тоот тусгай зөвшөөрлийн лицензийг Хангад Эксплорейшн компани эзэмшдэг. Хангад Эксплорейшн ХХК-ийн Баруун наран нүүрсний уурхай нь Монголын Уул Уурхайн Корпораци \ Энержи Ресурс ХХК\ бүрэлдэхүүн хэсэг юм. Баруун наран уурхайг 2012 оны 1 сард улсын комисст хүлээлгэн өгч улмаар нүүрс олборлолтын ажлыг эхлүүлсэн. Баруун наран уурхайгаас Ухаа худаг уурхай хүртэлх нүүрс тээврийн хатуу хучилттай зам тавьж 2012 оны 11 сард улсын комисст хүлээлгэн өгсөн. Ингэснээр нүүрс тээвэрлэлтийн явцад үүсэх тоос шороо, хөрс, ургамал талхлагдах байгальд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулснаас гадна тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хангаж чадсан. Баруун наран уурхайгаас 2023 онд 9 -р сарын 30-ны байдлаар 1,894,431 тонн нүүрс олборлосон.



Хүснэгт 1.1. Тусгай зөвшөөрлийн талбайн газар зүйн координат

Уртраг			Өргөрөг		
Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
105°	10'	0"	43°	37'	00"
105°	16'	0"	43°	35'	00"
105°	10'	0"	43°	38'	00"
105°	16'	0"	43°	34'	00"

1.1. Баруун наран уурхайн үйл ажиллагаа

Уурхайн нүүрсний үйлдвэрлэлийн нөөц 254.84 сая тонн болно. Энэхүү нөөцийг уурхайн ТЭЗҮ-д тусгагдсан хүчин чадлаар 26 жил ашиглахаар байна.

Ордын уул-геологийн нөхцлөөс хамааруулан уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлолтын ажлыг экскаватор-автосамосвалын хослолоор гүйцэтгэнэ. Хөрсийг гадаад овоолгод, нүүрсийг уурхайн мөргөцөгөөс нүүрсний агуулах хүртэл, агуулахаас Ухаа худагийн баяжуулах үйлдвэр хүртлэх тус тус тээвэрлэнэ. Олборлосон нүүрсийг уурхайн түр агуулахаас Ухаа худаг хүртэл тээвэрлэхдээ 31.6 км зайд тусгайлан бэлдсэн хатуу хучилттай замыг ашигладаг.



Зураг 1.1. Уурхайн захиргааны байр ба засварын төв, кемп

Уурхайн тосгон нь ордоос хойд зүгт 6 км зайд байрладаг. Тосгонд ажилчдын байр, гал тогоо, хоолны заал, халуун усны газар, уурын зуух, материалын агуулах зэрэг барилга байгууламжууд байна.

Зам усалгаа ба ногоон байгууламжийн усалгаанд уурхайгаас гарах шүүрлийн усыг ашиглана. Ундны болон ахуйн зориулалттай усыг уурхай ба тосгон дээр байрлах өрөмдмөл 2 гүний худгаас хангадаг болно. Цахилгаан эрчим хүчний хэрэглээг дизель генератор ашиглан хангаж байсан бол 2020 оны 9-р сард ЦДАШ-г ашиглалтанд оруулсан.

Уурхайн түлшний хэрэглээг уурхайн талбайд байрлах 50м³ х 4 нөөцлүүр бүхий шатахуун түгээх станцаас хангана.



Зураг 1.2. Уурхайн тосгон ба шатахуун түгээх станц

Нүүрс тээвэрлэлтийн авто зам: Баруун нарангаас Ухаа худаг уурхай руу нүүрс тээвэрлэх зорилгоор 31.8 км урттай хатуу хучилттай авто замыг 2012 оны 11 сард ашиглалтанд оруулсан. Нүүрсийг Ухаа худаг дахь баяжуулах үйлдвэрт боловсруулан, Ухаа худаг-Гашуун сухайт чиглэлд тээвэрлэж, экспортолно.

Баруун наран – Ухаа худаг чиглэлийн нүүрс тээвэрт хатуу хучилттай замыг ашиглаж байгаа нь уурхайн тээвэрлэлтийн хүчин чадал нэмэгдэж, зардал буурах боломжтой болж байгаагаас гадна хайрган зам ашигласнаас үүсэх тоосжилтыг бууруулж, говь нутгийн байгалийн тэнцвэрт байдлыг хадгалахад ихээхэн ач холбогдолтой юм.

Хатуу хучилттай зам нь цаг агаарын бүх нөхцлийг даах чулуун бүтэцтэй ба 100 тоннын даацтай тээврийн хэрэгсэл явахад зориулагдсан байна. Баруун наран- Ухаа худаг чиглэлийн хатуу хучилттай зам нь 10.5 метр өргөн, хөдөлгөөний 2 зурвастай, замд ус тогтохгүйгээр шууд зайлуулах бүрэн боломжтой.

1.2 Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын “Баруун нарангийн” нүүрсний орд нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Халхын дундад ба Дарьгангын талархаг мужийн А тойрог ухаа гүвээт халхын дундад талд хамрагдана.

Байгалийн мужлалаар Говийн их мужийн бор хөрсний бүсэд багтах ба газрын гадарга, газарзүйн хувьд нам уулс, ухаа гүвээ толгодод хамрагдана. Эдгээр нам уулс, ухаа гүвээ хооронд өргөн уудам задгай уудам хөндий, урт шилүүд үүсчээ.

Нам уулс, ухаа гүвээ толгод нь далайн түвшнээс дээш дунджаар 1500-1600 м орчим өндөрт, харин өргөн уудам задгай хөндий далайн түвшнээс дээш 1550 м өндөрт тус тус тогтоно. Энд хамгийн өндөр цэг Бумбатын хяр уул далайн түвшнээс дээш 1600 м, хамгийн нам цэг уурхайгаас урагш дэрстэй хоолой 1180 м өндөрт өргөгджээ.

1.2.1. Баруун наран уурхай орчмын хөрсний хэв шинжийн онцлог

Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь байгалийн мужлалаар Говийн их мужийн бор хөрсний бүсэд багтах ба газрын гадарга, газарзүйн хувьд нам уулс ухаа гүвээ толгодод хамрагдана. Хөрсний хээрийн судалгаа ба лабароторийн шинжилгээний үр дүнд үндэслэж доор дурьдсан хөрсний хэв шинж, дэд хэв шинж, төрөл, зүйлийг тогтоосон. Үүнд:

- Нам уулс, ухаа гүвээ толгодын сул хөгжилтэй чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн тал хөндийн үүрмэг чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн тал хөндийн чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн нугархаг хөрс
- Гуу жалга сайрын хөрс

1.2.2. Уур амьсгалын тойм

Даланзадгад хотын сүүлийн 10 жилийн агаарын температурын мэдээнээс харахад жилийн агаарын дундаж температур нь 5.8°C байна. Цогтцэций сумын жилийн агаарын дундаж температур 4.3°C байдаг байна. Жилийн хамгийн хүйтэн сар нь 1 дүгээр сар буюу дундаж агаарын температур нь $12.9 - 13.7^{\circ}\text{C}$, хамгийн дулаан сар нь 7 дугаар сар буюу дундаж агаарын температур нь $+23.1 - +24.5^{\circ}\text{C}$ байдаг байна. Уур амьсгалын дулаарлаас болж жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа, хүйтний нөөц багасч, дулаан үеийн үргэлжлэх хугацаа уртасч дулааны нөөц нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Төсөл хэрэгжих Баруун Нарангийн уурхай нь харьцангуй нам дор, өргөн уудам хөндийд, алсуураа говийн уулс, нам толгод, гүвээгээр хүрээлэгдэн орших ба жилийн ихэнх хугацаанд буюу дунджаар 210 орчим хоног дулаан байдаг байна.

Энэ бүс нутагт жилдээ 104.3 мм орчим хур тунадас унадаг. Хур тунадасны хэмжээ жилийн дотор нилээд өөрчлөлттэй хуваарилагддаг буюу 4-10 дугаар саруудад жилийн нийт хур тунадасны 68.93% нь унадаг боловч зөвхөн 7-8 дугаар саруудад 60-70% орчим нь унадаг байна. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын дулаарлаас шалтгаалан зүсрэн орох бороо цөөрч гол төлөв хүчтэй аадар борооны тоо олшрох болсон.

Жилийн дундаж салхины хурд 2.4-5.1 м/сек ба сүүлийн 10 жилд салхины хурд хамгийн ихдээ 30 м/сек хүрч ширүүсч байсан байна. Төслийн бүс нутагт хаврын улиралд салхины хурд харьцангуй их буюу 4.3-5.1 м/сек хурдтай байдаг. Өвлийн улиралд баруун, баруун хойд, хойд чиглэлийн салхи зонхилж байснаа зуны улиралд өмнөд зүгийн салхины давтагдал нэмэгдэж ирдэг зүй тогтолтой. Агаарын харьцангуй чийгшлийн их утга нь өвлийн саруудад ажиглагдах бөгөөд 1 ба 12 дугаар саруудад 50-68% байна. Хавар намарт агаарын харьцангуй чийгшлийн бага утга буюу 22-47% ажиглагдана.

1.2.3. Ургамлан нөмрөг, түүний онцлог

Оорцогийн хоолой буюу төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 20 овог, 46 төрөлд хамаарах 70 зүйл ургамал бүртгэгдсэн. Зүйлийн тоог нийт 4485,64 га талбайн хүрээнд харьцуулбал ургамлын янз зүйл 0.01 буюу төдийлэн баялаг биш ч тухайн говь цөлийн нөхцөлд байх ёстой хэмжээндээ байгаа юм. Овгуудын дотор хамгийн олон зүйлтэй нь Луулийн овог 11 зүйлтэй, Нийлмэл цэцэгтний овог 10 зүйлтэй, Үетний ба Буурцагт ургамлын овог тус бүр 5 зүйлтэй, бусад нь 1-2 зүйлтэй. Зүйлийн бүрдэлд унаган ургамлын тоо 9, Монгол улсын Улаан номонд орсон ховор зүйл 3 байна. Түүнчлэн зүйлүүдийн дотор 10 зүйл сөөг, 14 зүйл заримдаг сөөг, 1 зүйл сөөгөнцөр, 7 зүйл нэг наст ургамал байгаа бөгөөд бусад 28 зүйл ургамал нь олон наст өвслөг ургамал юм.

1.2.4. Амьтны аймаг, түүний онцлог

Төслийн талбай нь цөлөрхөг хээрийн бүслүүрт хамрагдаж байгаа бөгөөд Монгол орны хөхтөн амьтдын газар зүйн мужлалаар Дорнод говийн мужид хамрагдаж байгаа юм. Бүс нутгийн ургамлан

нөмрөгийг шүтэн өөхөн сүүлт атигдаахай, таван хуруут атигдаахай, соотон алагдаага, элсч савагдаахай, зэгэл алаг дааганцар, монгол даахай, бүрдийн шишүүхэй, орог зусаг, хадны барагчин, түвд ов, шар чичүүл, дагуур огдой зэрэг мэрэгчид байх ба түүгээр хооллодог маануул мий, саарал чоно, хярс үнэг, шар үнэг, өмхий хүрэн зэрэг амьтад байхаас гадна хулан адуу, янгир ямаа, хар сүүлт, аргаль хонь, цагаан зээр зэрэг салаа битүү туурайтан амьтад идээшилж бэлчээрлэдэг.

Баруун нарангийн талбайн хэмжээнд 6 багийн 35 зүйл хөхтөн амьтад тэмдэглэгдсэн байна. Эдгээрээс шилүүс, цоохондой, чоно, үнэг, хулан, янгир, хар сүүлт зээр, цагаан зээр зэрэг том хөхтөн амьтад нь ихэвчлэн хайгуулын талбайн баруун урд талаар орших уулс тэдгээрийн хооронд хөндийгөөр тохиолдоно. Харин талбай дотор ихэвчлэн жижиг мэрэгчид тархсан байдаг.

Суурь судалгааны хугацаанд 32 зүйл шувуу хайгуулын талбай болон орчмын бүсэд тэмдэглэгдсэн байна.

ТӨСЛИЙН ҮНДСЭН БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Баруун наран уурхайгаас нүүрс олборлох, боловсруулах, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг төслийг хэрэгжүүлэх байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тодорхойлсон байдаг.

Нүүрс олборлох, тээвэрлэх төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

2.1. Агаарын чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөллүүд:

- Ил уурхайн хөрс хуулалт, нүүрс олборлох, ачиж буулгах үйл ажиллагаа болон хөдөлгөөнт эх үүсвэрээс агаарт тоосонцорын хэмжээ ихсэх
- Элэгдэл эвдрэлд өртсөн газраас салхины нөлөөгөөр тоосжилт үүсэх
- Тэсэлгээ, уурхайд ажиллаж байгаа техник, тоног төхөөрөмжөөс үүсэх дуу шуугиан, Галлагаа, хүнд даацын болон бусад техникээс бохирдуулагч хий үүсэх

Болзошгүй сөрөг нөлөөллүүд:

- Нүүрс ачиж буулгах талбай дахь нүүрсний овоолгуудыг удаан хугацаагаар хадгалснаас нүүрс өөрөө халж шатсанаас хүлэмжийн хий ялгарах
- Төслийн хэмжээнд ашиглаж байгаа хатуу хучилттай зам эвдрэх, зам засах зэргээс шалтгаалан шороон зам гарган ашигласнаас агаарт тоосжилт үүсэх
- Шатахуун түгээх станц, тос тосолгооны материалын агуулахаас нэвчилт үүсэх, байгалийн гамшгийн улмаас бодис материал алдагдсанаас агаарт бодис материал ууршин тухайн орчны агаарыг бохирдуулах.

2.2. Усны чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Уурхайн олборлолтын явцад шүүрүүлэлтийн усыг шавхсанаас гүний усны түвшин буурах.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Уурхайн хотхон болон ажилчдын кэмийн бохир ус цэвэрлэх байгууламжийн эвдрэл гэмтэл, технологийн горим алдагдсанаас үүдэн гадаргын болон газрын доорх усны чанар найрлагад нөлөөлөх.

- Хаягдал чулуулгийн овоолго дахь хүчил шүлтийн тэнцвэр алдагдаж хүчиллэг урсацын нөлөөгөөр гадаргын болон газрын доорх ус бохирдох.

2.3. Хөрсний чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын хэлбэр төрхөд өөрчлөлт орох.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орох.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Салаа зам үүсгэснээс шалтгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орох.
- Тос тосолгооны материал, бохир ус асгарснаас шалтгаалан хөрс бохирдох.
- Хатуу хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох.
- Борооны усны угаагдал, үерийн усны улмаас бохирдол зөөгдөн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах.

2.4. Ургамлан бүрхэвчид үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Олборлолт явуулах талбайн шимт хөрсийг хуулж овоолго үүсгэснээр тухайн газрын ургамлан бүрхэвч устах.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орж тухайн хэсгийн ургамлан бүрхэвч доройтох.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Салаа зам үүсгэснээс шалтгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орж ургамлан бүрхэвчид нөлөөлөх.
- Тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан ургамлын ургалтанд нөлөөлөх.
- Төслийн үйл ажиллагааны улмаас үүсэх тоосжилт ургамлын гадаргууд бууснаар фотосинтезийн процессийг багасгаж ургамлын ургалтанд нөлөөлөх

2.5. Биологийн төрөл зүйлд үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

Үндсэн сөрөг нөлөөлөл:

- Уул уурхай түүнийг дагасан үйлдвэр, суурьшлаас тухайн бүс нутгийн амьтан дайжих, дүрвэх.
- Уурхайн хөрс хуулалт, хашаажуулалт зэргээс амьтны амьдрах орчин, идэш тэжээл хязгаарлагдах.

Болзошгүй сөрөг нөлөөлөл:

- Нүүрс тээврийн зам хөндлөн гарах амьтад машинд дайруулах.

БАРУУН НАРАН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН

Өмнөговь аймгийн Ханхонгор суманд орших Баруун нарангийн ордоос нүүрс олборлох, тээвэрлэх төслийн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийн байдлыг нэг бүрчлэн тодорхойлж,

шаардагдсан хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно.

2023 оны Баруун наран уурхайн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн гол үйл ажиллагаанууд, түүний үр дүнг дурдвал.

- Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн оффис ба хатуу хучилттай зам дагуу 2500ш мод тарьсан, мөн мод тарьж ургуулах ТЭЗҮ-н дагуу Хэнтий аймагт 8000ш мод тарьсан.
- Дүйцүүлэг хамгаалах ажлын хүрээнд Говь 3 сайханы байгалийн цогцолборт газрын Баяндалай сумын нутаг Баянцагааны нуруу орчим гар аргаар алт олборлосон Хувийн гол нэртэй нэртэй газар 1.15 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг ажлыг гүйцэтгэж, орон нутгийн ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.
- Нөлөөллийн бүсийн айл өрхөд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд Хондот багт 500 боодол өвс, нөлөөллийн бүсийн 20 өрхөд нийт 500 боодол өвс 125 уут тэжээлийн дэмжлэг тусламжийг үзүүлсэн байна.
- Баруун наран уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй болзошгүй ба гол сөрөг нөлөөллийг хянах зорилгоор агаарын чанар, газар доорх ус, хөрсөн бүрхэвч зэрэг чиглэлээр орчны хяналт шинжилгээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэнд нэгтгэн илэрхийлэв.

Хүснэгт 2. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт

д/д	Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл	Төлөвлөсөн ажлын тоо	Гүйцэтгэсэн ажлын тоо	Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	10	10	-
2	Нөхөн сэргээлт	2	2	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	3	3	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	1	1	-
5	Хог хаягдлын менежмент	6	6	-
6	Осол эрсдлийн менежмент	3	2	-
7	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	5	5	-
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	9	9	-
9	Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа	3	3	-
	Нийт	41	41	-

4. СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөлийг бууруулах чиглэлээр

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Усны машин ашиглан тоосжилт үүсэх зам, талбайг услах	Ил уурхай	Уурхай ажиллаж эхэлсэн үеэс хойш технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулахаар шүүрлийн ус ашиглан 20 тоннын 1, 18 тоннын 1 зориулалтын шүршдэг усны машинаар зам усалгаа хийсэн.	Үйлдвэрлэлийн зардлаас	5000 м ³ /сар
2	Уурхайн технологийн машины хурдны хязгаарт хяналт тавьж, замын арчилгааг хийж үүсэх тоосыг бага байлгах	Ил уурхайн	Баруун наран уурхайд ажиллаж буй тээврийн хэрэгсэлийн хурдыг дотоод журмын дагуу технологийн замд 50км\ц, налуу замд 30км\ц, отвол дээр 40км\ц, ромын талбай буюу нүүрсний овоолго дээр 10км\ц, засварын талбайд 10 км\ц байхаар зааж хурд хэмжилтийг хийж, тоосжилтоос сэргийлж байна.		50км\ц
3	Дэгдэмхий органик нэгдэл тодорхойлох шинжилгээ хийлгэх.	ШТС	Баруун наран уурхайн ШТС орчимд мэргэжлийн байгууллагаар агаарын сорьцыг	300.00	1ш
НИЙТ ЗАРДАЛ, мян төг				300.00	

4.1.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

Тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайгаас шүүрэх шүүрлийн ус болон 20 тоннын 1, 18 тоннын 1 зориулалтын шүршдэг усны машинаар зам талбайг услаж байна. Уурхайд ажлын байрны үзлэгийг тогтмол хийж технологийн замд эвдрэл гэмтэл гарах тухай бүрд туслах техник ашиглаж засвар үйлчилгээг хийж тоосжилтын хэмжээг бууруулж байна.



Зураг 4.1.1.1. Уурхайн технологийн замын усалгаа

4.1.2. Уурхайн тээврийн машины хурдны хязгаарт хяналт

Баруун наран уурхайд ажиллаж буй тээврийн хэрэгсэлийн хурдыг дотоод журмын дагуу технологийн замд 50км\ц, налуу замд 30км\ц, отвол дээр 40км\ц, ромын талбай буюу нүүрсний овоолго дээр 10км\ц, засварын талбайд 10 км\ц байхаар зааж хурд хэмжилтийг хийж, тоосжилтоос сэргийлж байна.



Зураг 2.1.2.1. Хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ

4.1.3. Дэгдэмхий органик нэгдэл тодорхойлох шинжилгээ хийлгэх

Баруун наран уурхайн шатахуун түгээх станц орчмын дэгдэмхий органик нэгдлийн хэмжээг тодорхойлох зорилгоор ШТС-ын орчмоос 3-р сарын 22-нд дээж авч “Ногоон Титэм” ХХК-ын лабораториор шинжлүүлсэн. Шинжилгээний үр дүнгээр агаарын чанарын стандартаас хэтэрсэн үзүүлэлт байхгүй байна.

Хүснэгт 3. Дэгдэмхий органик нэгдэлийн шинжилгээний үр дүн, 2023 он

№	Тодорхойлох үзүүлэлт	Шинжилгээний үр дүн, мкг/м ³	MNS 4585:2016
1	Бензол	0.5	1
2	Толуол	0.7	2900
3	Этилбензол	0.5	850
4	м, п ксилод	0.8	500

4.2. Газар доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

№	Байгаль орчны хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Уст цэгт хамгаалах, сайжруулж сэргээх ажил зохион байгуулах	Уурхай орчмын уст цэгүүд	Ханхонгор сумын Мандах багийн нутагт байрлах Их хүйтэнгийн булгийн эхийг хамгаалах зорилгоор хамгаалалтын хашаа барьж, байгуулав.	3,000.0	250 м
2	Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох байгууллагаар гаргуулж гэрээ байгуулах,	Хангад эксплорэйшн ХХК	Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаагаар ус ашиглах дүгнэлт гаргуулав.	Үйл ажиллагааны зардлас	1 ш
НИЙТ ЗАРДАЛ, мян төг				3,000.0	

4.2.1. Уст цэгийг хамгаалах, сайжруулах сэргээх



Ханхонгор сумын Мандах багийн нутагт байрлах Их хүйтэнгийн булгийн эхийг хамгаалах зорилгоор 250 м хамгаалалтын хашаа барьж, байгуулав.



Зураг 4.2.1.1. Их хүйтэнгийн булгийн эхийг хашсан байдал

4.2.2. Ус ашиглах дүгнэлт гаргуулах

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.8 дэх хэсгийг үндэслэл болгон унд, ахуйн хэрэгцээг 2 ш гүний худгаас, зам, талбай, уурхайн тоосжилт дарах усны хэрэгцээг газрын доорх шүүрлийн уснаас хангах, унд ахуйд хоногт 75.3м³ ус ашиглах, улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч шинжлүүлэн Усны газар хүргүүлж байх нөхцөлтэйгээр Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаагаар ус ашиглах дүгнэлт гаргуулав. 5 жилийн хугацаатай олгосон ус ашиглах зөвшөөрөл, дүгнэлтийг хавсаргав.

 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ УСНЫ ГАЗАР Чингүнжавын гудамж, 2 дугаар хороо, Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16050 Утас/Факс: (976-51) 26 55 73, (976-51) 26 55 36, Цахим шуудан: office@water.gov.mn, Цахим хуудас: www.water.gov.mn 2023. 01. 24 № 01193 танай 2023. 01. 03-ны № 01 -Т	 БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ ГАЛБА-ӨӨШ-ДОЛООДЫН ГОВИЙН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН ТУШААЛ 2023 оны 02 сарын 14 өдөр Дугаар 1/05 Сайншанд сум
"ХАНГАД-ЭКСПЛОРЕЙШН" ХХК-д	Зөвшөөрөл олгох тухай
<p>Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, танай байгууллагын 2023 оны 01 дугаартай албан бичгээр ирүүлсэн хүсэлт, холбогдох бичиг баримтыг судалж үзээд Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт орших Барууннарангийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах төсөлд ус ашиглуулах дүгнэлтийг гарган хавсралтаар хүргүүлж байна.</p> <p>Хувийг Галба-Өөш, Долоодын говийн сав газрын захиргаанд.</p> <p>Хавсралт 3 хуудастай.</p> <p>ДАРГА  Ш.МЯГМАР</p> <p style="text-align: right;">182330157</p>	<p>Монгол Улсын Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.14, 28 дугаар зүйлийн 28.6, 28.8 дахь заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2, 8.1 дүгээр зүйлийн 1.28 дахь заалт, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.20 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн "Улсын тэмдэгтийн хураамжийн хувь, хэмжээг тогтоох тухай" 199 дүгээр тогтоолын 11.1.19 дэх заалт, Усны газрын 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:</p> <ol style="list-style-type: none">Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутагт байрлах Баруун наран нүүрсний ордыг ил аргаар ашиглах төслийг хэрэгжүүлэгч "Хангад эксплорейшн" ХХК-нд дүгнэлтэд заасан эх үүсвэрээс 5 жилийн хугацаатай ус ашиглахыг зөвшөөрсүгэй.Ус ашиглах зөвшөөрлийн Улсын тэмдэгтийн хураамж 200,000 (Хоёр зуун мянга) төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, ус ашиглах дүгнэлтийг үндэслэн жил бүр гэрээ байгуулах, ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавих шаардлагыг ханган ажиллаж, усны мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбогдсон мэдээ, тайланг жил бүрийн 12 дугаар сарын 30-ны дотор ирүүлэхийг "Хангад эксплорейшн" ХХК-ийн дэд ерөнхийлөгч (Ц.Баасандорж)-д үүрэг болгосугай.Усны ашиглах боломжит нөөц, ус ашиглалтын байдалд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын доорх усны нөөц, ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (Э.Ундрахгэрэл), ус ашиглагчтай гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг дараа оны 01 дүгээр сард багтаан дүгнэж байхыг Усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан мэргэжилтэн (Э.Жанчивдорж) нарт даалгасугай. <p>ДАРГА  Б.ЯЛАЛТБАЯАР</p>

Зураг 4.2.2.1. Ус ашиглах дүгнэлт болон зөвшөөрөл

4.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах ба уг үйл ажиллагаанд хяналт тавих	Ил уурхай	Тайлант хугацаанд хаягдал чулуулгийн талбайн тэлэлтэй холбогдуулан 199,583м ³ шимт хөрсийг хуулан овоолго үүсгэсэн байна.	Үйлдвэрлэлийн зардлаас	199,583м ³
2	Шимт хөрсний судалгаа хийлгэх	Ил уурхай	Баруун наран уурхайн ойрын 5 жилийн ахилтанд өртөх хөрсөн бүрхэвчийн судлагааг Монгол улсын холбогдох стандартын дагуу, шинжлэх ухааны нийтлэг арга аргачлалаар өгөгдсөн цэгүүдэд хийж, хөрсний зузааны зураглал хийх болон шаардлагатай дата мэдээлэл бэлтгэх ажлын даалгавар боловсруулан ажиллаж байна.	Үйлдвэрлэлийн зардлаас	Мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэв.
3	Нүүрс тээврийн автомашинуудад хучлага ашиглах	Нүүрс тээврийн үйл ажиллагаа	Баруун наран уурхайгаас Ухаа худаг чиглэлд нүүрс тээвэрлэж буй тээврийн машинуудад хучлагыг тогтмол ашиглан нүүрсний асгаралтаас сэргийлэн ажиллаж байна.	Үйлдвэрлэлийн зардлаас	Бүх автомашин
НИЙТ ЗАРДАЛ, мян төг					-

4.3.1. Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах ба уг үйл ажиллагаанд хяналт тавих

Уурхайн ухмал болон хаягдал чулуулагын овоолгын тэлэх талбай болон бусад үйл ажиллагааны нөлөөгөөр эвдрэлд орох газрын шимт хөрсийг “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс, хуулалт, хадгалалт MNS 5916:2008” стандартын дагуу хуулж хадгалдаг. Шимт хөрсний овоолго тус бүрийг дугаарлаж овоолго хийсэн огноо, хөрсний эзлэхүүн зэрэг мэдээллүүдийг оруулан бүртгэлжүүлж байна. Тайлант хугацаанд хаягдал чулуулгийн талбайн тэлэлтэй холбогдуулан 199,583 м³ шимт хөрсийг хуулан овоолго үүсгэсэн байна.



Зураг 4.3.1.1. Шимт хөрс хуулж байгаа нь

4.3.2. Шимт хөрсний судалгаа хийлгэх

Баруун наран уурхайн ойрын 5 жилийн ахилтанд өртөх хөрсөн бүрхэвчийн судлагааг Монгол улсын холбогдох стандартын дагуу, шинжлэх ухааны нийтлэг арга аргачлалаар өгөгдсөн цэгүүдэд хийж, хөрсний зузааны зураглал хийх болон шаардлагатай дата мэдээлэл бэлтгэх ажлын даалгавар боловсруулан ажил гүйцэтгэх компанийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.

4.3.3. Нүүрс тээврийн автомашинуудад хучлага ашиглах

Баруун наран уурхайгаас Ухаа худаг чиглэлд нүүрс тээвэрлэж буй тээврийн машинуудад хучлагыг тогтмол ашиглан нүүрсний асгаралтаас сэргийлэн ажиллаж байна.



Зураг 4.3.3.1. Нүүрс тээвэрлэж буй хучлагатай автомашин

4.4. Ургамал, амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
---	--------------------------------------	--------------	-----------------	---------------------	------------

1	Оффис орчмын ногоон байгууламжийн модны усалгаа, арчилгааг зохион байгуулах	Уурхайн талбай	Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн оффис ба хатуу хучилттай зам дагуу 2500ш мод тариалж, модны усалгааг 5-р сараас эхлүүлэн хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд 10-р сарын дундуур модны цэнэг усалгаа хийж өвлийн бэлтгэл ажлыг хангаж ажиллав.	2,000.0	2500ш мод
2	Ухаа худагаас Баруун наран явах цахилгаан шугамын дагуу шувуудын хорогдол гарч буй эсэхэд ажиглалт явуулах	Цахилгааны шугам сүлжээний дагуу	Баруун наран уурхайгаас Ухаа худаг чиглэлийн цахилгааны шугамын дагуу хийгдсэн хоёр удаагийн ажиглалтаар шувууны хорогдол гараагүй. Харин махчин шувууд үүрлэсэн байна.	1,000.0	Жилд 1 удаа
НИЙТ ЗАРДАЛ, мян төг				3,000.0	

4.4.1. Оффис орчмын ногоон байгууламжийн модны усалгаа, арчилгаа

Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн оффис ба хатуу хучилттай зам дагуу 2500ш мод тариалж, модны усалгааг 5-р сараас эхлүүлэн хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд 10-р сарын дундуур модны цэнэг усалгаа хийж өвлийн бэлтгэл ажлыг хангаж ажиллав.



Зураг 4.4.1.1. Баруун наран уурхайн оффис орчмын ногоон байгууламж

4.4.2. Ухаа худагаас Баруун наран явах цахилгаан шугамын дагуу шувуудын хорогдол гарч буй эсэхэд ажиглалт явуулах

Ухаа худагаас Баруун наран явах цахилгааны шугамын дагуу шувуудын хорогдлын ажиглалтын 4 болон 9-р сард хийсэн. Уг хоёр удаагийн ажиглалтаар тогонд цохиулан үхсэн шувуу ажиглагдсангүй. Харин 4-р сарын 06-нд хийсэн агаарын шугамын 62, 61, 37, 237-р тулгуурын дээд хэсэгт махчин шувуу үүрлэсэн байна. Үүрлэсэн агаарын шугамын дор их шувууны хоолны яс үлдэгдэл хуримтлагдсан нь ажиглагдаж байна.



Зураг 4.4.2.1. Ухаа худагаас Баруун наран явах цахилгааны шугамын тулгуурын хэсэгт
үүрлэсэн махичин шувууны үүр

5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Тэр бум мод хөтөлбөрийн хүрээнд мод тарьж ургуулах	Тэр бум мод хөтөлбөр	Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд уурхайн оффис ба хатуу хучилттай зам дагуу 2500ш мод тарьсан, мөн мод тарьж ургуулах ТЭЗҮ-н дагуу Хэнтий аймагт 8000ш мод тарьсан.	Тэр бум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас зарцуулсан	10, 500ш мод тарив.

2	Ажилдын хотхон орчмын мод тарьсан талбайн модны усалгаа, арчилгааг зохион байгуулах	Ажилчдын хотхон орчим мод тарьсан талбай	Кэмпийн гадна талбайд 2022 онд байгуулсан 2га талбайн ногоон байгууламжид усалгааны систем суурьлуулж, 800ш мод нөхөн тарьж усалгаа арчилгааг хуваарийн дагуу гүйцэтгэсэн.	3,000.0	2 га
НИЙТ ЗАРДАЛ, мян төг				3,000.0	

5.1. Тэр бум мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд мод тарих

Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилтын дагуу Баруун наран уурхайн тохижилтонд зориулан оффисын гадна талбайд болон уурхайруу нэвтрэх хатуу хучилттай зам дагуу хаврын тарилтаар нийт 2500ш модны суулгац тарьж, усалгаа арчилгааг гүйцэтгэсэн. Тарилтанд говь тарьж ургуулсан улиас, хайлаас, жигд сухай модны 2 настай суулгацыг ашигласан. Мөн Хондот багийн иргэдийн мод тарих санал санаачлагыг дэмжиж хавар 270ш суулгац, намар 220ш модны суулгац, хамгаалалтын торон хашаа, усны нөөцлүүр, усалгааны систем зэргийг хүсэлтийн дагуу олгосон.

Компани тэр бум модны хөтөлбөрт оролцох 2030 он хүртэл тарьж ургуулах модны үүрэг амлалтын хүрээнд ТЭЗҮ-г мэргэжлийн байгууллагаар боловсруулсан бөгөөд уг урт хугацааны төлөвлөлтийн дагуу Хэнтий аймгийн Хэрлэн сумын нутагт тариалангийн талбайн хамгаалалтын зурвас байгуулах ажилд Метагро ХХК-тай хамтран 8000ш мод тарьж ургуулсан.



Зураг 5.1.1 Оффисын гадна талбай, зам дагуу мод тарьсан байдал



Зураг 5.1.2 Хэнтий аймагт мод тарьсан байдал

5.2. Ажилчдын хотхоны мод тарьсан талбайн усалгаа, арчилгааг зохион байгуулах

Баруун наран уурхайн тохижилтонд зориулан оффисын гадна талбайд хаврын тарилтаар 200 мод, намрын тарилтаар 1000 мод тарьсан. Тарилтанд говьд тарьж ургуулсан Улиас, Хайлаас, Жигд, Сухай модны 2 настай суулгацыг тарьсан. Оффисын гадна талбайн ногоон байгууламж болон ажилчдын кемп орчмын модны усалгааг 5-р сараас эхлүүлэн хуваарийн дагуу хийж гүйцэтгэсэн бөгөөд 10-р сарын дундуур модны цэнэг усалгаа хийж өвлийн бэлтгэл ажлыг хангаж ажиллав.



Зураг 5.2.1 Ажилчдын хотхоны гадна талбайн ногоон байгууламжийн усалгааны систем



Зураг 5.2.2 Ажилчдын хотхоны гадна талбайн ногоон байгууламж

6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Их уул орчмын уулын туруутан амьтдыг хамгаалах зорилгоор хаврын улиралд биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх	Их уул	Бага хайрхан уулын орчимд тархан суурьшсан аргаль 4 толгой, янгир 4 орчим толгой зэрлэг ан амьтдад 20 боодол өвс тарааж өгч биотехникийн арга хэмжээ зохион байгуулав.	2,000.0	Жилд 1 удаа
2	Их уул орчмын уулын туруутан амьтдыг хамгаалах зорилгоор Зэрлэг амьтдад зориулсан уст цэгийг ажиллуулах	Их уул	2020 онд байгуулсан автомат ажиллагаатай уст цэгийн ажиллагааг тогтмол шалгаж, 2023 онд хөдөлгөөн мэдрэгч камер суурилуулж зэрлэг амьтны ажиглалтыг хийж байна.	1,000.0	Жилд 1 удаа
3	Зэрлэг амьтдын амьдрах орчинг сайжруулах зорилгоор эвдэрсэн газарт нөхөн сэргээлт хийх	Ханхонгор сумын нутагт байрлах Хуцын булаг	Говь 3 сайханы байгалийн цогцолборт газрын Баяндалай сумын нутаг Баянцагааны нуруу орчимд гар аргаар алт олборлосон Хувийн гол нэртэй газар 1.15 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг ажлыг гүйцэтгэж, орон нутгийн ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.	4,500.0	1 га
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг				7,500.0	

6.1. Уулын туруутан амьтдад зориулан хаврын улиралд биотехникийн арга хэмжээг хэрэгжүүлэх

2023 оны 02 дугаар сарын 18-ны өдөр Бага уулын орчимд байх Аргаль Янгирын сүргийн бэлчээрт 10 боодол өвсийг малчин Батмөнхийн хамт байршуулж биотехникийн арга хэмжээг зохион байгуулав.



Зураг 6.1.1. Өвс тээвэрлэж буй байдал



Зураг 6.1.2. Туруутан амьтдад зориулан тарааж тавьсан байдал

6.2. Зэрлэг амьтдад зориулсан уст цэгийг ажилуулж

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд мэргэжлийн байгууллагын суурь судалгааны үр дүн ба Өмнөговь аймгийн БОАЖГ-с өгсөн чиглэлд үндэслэн 2018 оноос хойш Ханхонгор сумын Хондот багийн нутаг болох Их ууланд уулын туруутан амьтдын популяцийг хамгаалах, амьдрах орчныг тэтгэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2020 онд Их ууланд зэрлэг амьтдад зориулан автомат ажиллагаатай уст цэг байгуулсан. 2023 онд зэрлэг амьтдад зориулсан уст цэгийн үйл ажиллагааг тогтмол шалгаж худаг хэвийн хэдийн ажиллаж байна. Уст цэгт ойр орчимд хөдөлгөөн мэдрэгч камер суурилуулж зэрлэг амьтны ажиглалтыг хийж байна.



Зураг 6.2.1. Зэрлэг амьтдад зориулсан уст

6.3. Эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх

Засгийн газрын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан Монгол орны хэмжээнд уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрч эзэнгүй орхигдсон талбайг нөхөн сэргээх зорилтын хүрээнд манай компани Говь 3 сайханы байгалийн цогцолборт газрын Баяндалай сумын нутаг Баянцагааны нуруу орчим гар аргаар алт олборлосон Хувийн гол нэртэй нэртэй газар 1.15 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг ажлыг гүйцэтгэж, орон нутгийн ажлын хэсэгт хүлээлгэн өгсөн.



Зураг 6.3.1. Нөхөн сэргээлт хийхийн өмнө



6.3.2. Нөхөн сэргээлт хийсний дараа

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус компани нь 2012 оноос эхлэн төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн нийт айлыг нүүлгэн шилжүүлж нөхөн олговор олгосон бөгөөд одоогоор нүүлгэн шилжүүлэх өөр айл өрх байхгүй тул энэ онд дээрх үйл ажиллагаатай холбоотой ажил уг төлөвлөгөөнд тусгагдаагүй болно.

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
7.1	Нөлөөллийн бүсийн айл өрхөд өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх	Нөлөөллийн бүсийн айл өрх	Хондот багт 500 боодол өвс, нөлөөллийн бүсийн 20 өрхөд нийт 500 боодол өвс 125 уут тэжээлийн дэмжлэг тусламжийг үзүүлсэн байна.	Орон нутгийн төсөл хөтөлбөрийн зардлаас	500 боодол өвс

7.1 Нөлөөллийн бүсийн айл өрхөд өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх

Өвс тэжээлийн тусламжийг хүлээлгэн өгөх ажлыг Орон нутгийн хөгжлийн нэгжээс зохион байгуулж сумдын удирдлагууд болон багийн дарга нартай хамтран 2023 оны 01-р сард Хондот багт 500 боодол өвс, нөлөөллийн бүсийн 20 өрхөд нийт 500 боодол өвс 125 уут тэжээлийн дэмжлэг тусламжийг үзүүлсэн байна.



Зураг 7.1.1. Баруун наран уурхайн малчдад өвс хүлээлгэн өгч буй байдал

8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Тус компани нь 2012 оноос хойш холбогдох хууль ба компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд түүх соёлын биет ба биет бус өвийг хамгаалах чиглэлээр тодорхой ажлуудыг хийж хэрэгжүүлсэн бөгөөд холбогдох хуулийн дагуу төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө археологи, палентлогийн хайгуул судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, авран хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Энэ онд түүх соёлын өвийг хамгаалах чиглэлээр үргэлжлэн хийгдэх ажил төлөвлөгдөөгүй бөгөөд цаашид түүх соёлын өвийг хамгаалах чиглэлээр тухай бүр шаардлагатай арга хэмжээг санаачлан зохион байгуулна.

9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Баруун нарангийн уурхайн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл авах шаардлага бүхий химийн бодисыг ашиглахгүй бөгөөд химийн бодис ашиглах лаборатори болон бусад үйл ажиллагаа явагдахгүй болно. Баруун наран уурхайгаас олборлосон нүүрсний химийн шинжилгээ Ухаа худаг төслийн нүүрс химийн лабораторид хийгдэх юм. Тиймээс тус төлөвлөгөөнд химийн бодисын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа төлөвлөгдөөгүй болно.

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1	Уурхайн ажиллагсдыг аюулгүй	Уурхайн хэмжээнд	Баруун наран уурхайд ажиллахаар шинээр ирсэн бүх үндсэн болон гэрээт компанийн ажиллагсдад	500.0	1582 үндсэн болон

	ажиллагаа, осол эрсдлээс урьдчилан сэргийлэх сургалтанд хамруулах		компанийн аюулгүй ажиллагаа, байгаль орчин, галын аюулгүй байдал, анхны тусламжийн 12 цагийн сургалтанд хамруулсан байна. 2023 онд давхардсан тоогоор нийт 1582 үндсэн болон гэрээт компани ажиллагсад сургалтанд хамрагдсан байна.		гэрээт компани ажиллагсад
2	Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг хийх, сургалт зохион байгуулах	Баруун наран уурхай	Баруун наран уурхайн Уурхайн менежер Г.Баттулга гэрээт олборлогч компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтнуудад гал унтраах автомашинд үзлэг шалгалт хийж, гал унтраах автомашины багаж хэрэгслийн ажиллуулах чиглэлээр заавар зөвлөмжийг өгсөн.	1,500.0	2-р улиралд
3	Шатахуун түгээх станцын нөөцийн сав, цэнэглэх, хүлээн авах талбайд засвар үйлчилгээ, тохижилтын ажил гүйцэтгэх	ШТС	Баруун наран уурхайн аюултай хог хаягдлыг /хаягдал тос, тосоор бохирдсон материал, тосны сав, агаар шүүгч, тосны шүүр г.м/ хадгалах талбайг энэ онд шинээр байгуулж хамгаалалтын хашааг барьсан. Тухайн талбайд аюултай хог хаягдлыг хадгалах шаардлагад нийцүүлж 40 тн багтаамжтай тосны сав, 40 тн багтаамжтай битүү агуулах байршуулж, хаягдал шингэн материал байршуулах талбайг хатуу хучилттай болгосон.	Үйл ажиллагааны зардлаас	3-р улиралд
Нийт зардал				2,000.0	

9.1. Уурхайн ажиллагсдыг сургалтанд аюулгүй ажиллагааны сургалтанд хамруулах

Баруун наран уурхайд ажиллахаар шинээр ирсэн бүх үндсэн болон гэрээт компанийн ажиллагсад компанийн аюулгүй ажиллагаа, байгаль орчин, галын аюулгүй байдал, анхны тусламжийн 12 цагийн сургалтанд хамруулсан байна. 2023 онд давхардсан тоогоор нийт 1582 үндсэн болон гэрээт компани ажиллагсад сургалтанд хамрагдсан байна.



Зураг 9.1.1. Сургалтанд хамрагдсан байдал

9.2. Галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг хийх, сургалт зохион байгуулах

Баруун наран уурхайн Уурхайн менежер Г.Баттулга гэрээт олборлогч компанийн Хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтнуудад гал унтраах автомашинд үзлэг шалгалт хийж, гал унтраах автомашины багаж хэрэгслийн ажиллуулах чиглэлээр заавар зөвлөмжийг өгсөн. Мөн Баруун наран уурхайн засварын байр, оффист, гэр кемпэд галын аюулаас урьдчилсан сэргийлэх үзлэг шалгалт хийж, гал унтраагуурын даралт болон ажиллагааг шалгах зөвлөмжийг газар дээр нь өгч ажилласан.

ХАБ-ын Аяны хүрээнд 09.26 ны өдөр нийт ажилчдад Онцгой байдлын сургалт болон Онцгой байдлын дохиогоор ER аврах бүлгийн Галын аюулаас урьдчилан сэргийлэх сургалтууд орсон.

Засвары болон оффисын хэсгийн галын сарайны иж бүрдлийг нөхөж бүрдүүлсэн.

Техникийн бэлэн байдал галын хор, дугуйн ивүүр, Анхны тусламж, бүхээгийн эмх цэгц, шил толь, гэрэлтүүлэг г.м хэвийн байгаа эсэхэд төлөвлөгөөт үзлэгийг 08-р сарын 10-ны өдөр хийж гүйцэтгэж хариу арга хэмжээг авсан.



Зураг 9.2.1. Галын аюулгүй байдлын практик сургалт зохион байгуулж буй, галын сарайг бүрдүүлсэн байдал, сургалтын бүртгэл

9.3. Шатахуун түгээх станцын нөөцийн сав, цэнэглэх, хүлээн авах талбайд засвар үйлчилгээ, тохижилтыг сайжруулах

Баруун наран уурхайн аюултай хог хаягдлыг /хаягдал тос, тосоор бохирдсон материал, тосны сав, агаар шүүгч, тосны шүүр г.м/ хадгалах талбайг энэ онд шинээр байгуулж хамгаалалтын хашааг барьсан. Тухайн талбайд аюултай хог хаягдлыг хадгалах шаардлагад нийцүүлж 40 тн багтаамжтай тосны сав, 40 тн багтаамжтай битүү агуулах байршуулж, хаягдал шингэн материал байршуулах талбайг хатуу хучилттай болгосон.

Аюул осол гэмтэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор анхааруулах тэмдэг, самбарыг шаардлагатай цэгт байршуулж, хамгаалалтын далан хийж, өнгө үзэмжийг нэмэгдүүлэх зорилгоор будаж сайжруулсан.



Зураг 9.3.1. Аюултай хог хаягдал хадгалах талбай

10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Тоо хэмжээ
1.	Уурхай орчмын зам талбайд цэвэрлэгээ зохион байгуулах	Уурхай орчим	Тайлант хугацаанд уурхайн зам талбайд тархсан хог хаягдлын цэвэрлэгээг бүх хэлтэс нэгжүүд хуваарийн дагуу 7 хоног бүрийн Бямба гариг бүрт цэвэрлэгээ хийсэн байна. Нийт 41 удаагийн цэвэрлэгээгээр 85.3м ³ хог зайлуулсан байна.	1,000.0	Уурхайн үйл ажиллагаа үргэлжилж байх үед
2.	Хуванцарын хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэртнийлүүлэх	Хог хаягдал түр хадгалах цэгүүд	Ажилчдын хотхон, засварын шоп, оффисийн өрөөнүүд, уулын хэсэгт паркийн талбай, түлш олгох хэсэгт хог хаягдлыг ангилан хийх өнгөний код, тэмдэглэгээтэй савнуудыг байршуулсан. Хогийн саванд хуримтлагдсан ангилагдсан хог хаягдлыг тус тусад уутлан хуванцар, картон, гялгар уут зэрэг дахивар хог хаягдлыг гэрээт “Дүүрэн Цэций” ХХК-ийн дахивар авах цэгт тухай бүрт тогтмол нийлүүлж байна.	Үйл ажиллагааны зардлаас	Уурхайн үйл ажиллагаа үргэлжилж байх үед

			Тайлант хугацаанд нийт 151.5 м3 хуванцрыг гэрээт компаниар дамжуулан дахин боловсуулах үйлдвэрт хүргүүлсэн байна.		
3.	Хаягдал тосыг шаардлага хангасан нөхцөлд цуглуулж, эрх бүхий байгууллагад нийлүүлэх	Засварын төв	Техникийн засвар үйлчилгээнээс гарсан хаягдал тосыг Баруун наран уурхайн баруун, зүүн уурхайн аюултай хог хаягдлын нэгдсэн цэгт хуримтлуулж байна. Сав 2/3 хэмжээнд хүрсэн үед эрх бүхий гэрээт байгууллага “Түмэн Эгшиг” ХХК-ийн зориулалтын машинаар тээвэрлэсэн байна. Нийт 17,8 тонн тосыг 2 удаа энэ цэгээс тээвэрлэлт хийгдсэн байна.	Үйл ажиллагааны зардлаас	Улирал тутам
4.	Аюултай хог хаягдлыг хадгалах талбайг тохижуулж сайжруулах	Тостой хог хаягдлын талбай	Аюултай хог хаягдал хадгалах талбайг Баруун уурхайн гэрээт компани болон UARP ХХК, Зүүн уурхайн гэрээт компани болох SG coal mining ХХК-тай хамтран 5-р сард 25 тонны хаягдал тос хадгалах ёмкость болон аюултай хог хаягдал хадгалах контейнар зэргийг байршуулж хөмсөг бордюр хийн, шаардлагатай хаягжуулалтыг дотоод журам болох Хог хаягдлын удирдлага зохицуулалтын журмын дагуу хаягжуулалт хийсэн.	1,200.0	6-р сард
5	Хог хаягдлын чиглэлээр сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчид	Хог хаягдлын удирдлага зохицуулалтын журмын агуулгаар уул, засвар, кемпийн ажилчдад сургалт, сэдэвчилсэн яриаг 15 удаа хийсэн ба 409 ажилтан хамрагдсан. “Хог хаягдлыг ангилан ялгаж хэвшье” уриалга бүхий сурталчилгааны зурагт хуудас бэлтгэн нийт ажилчидад тарааж өгсөн. Олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор хог мэдээллийн самбар хийж, Улаанбаатар-Өмнөговь чиглэлийн төв замын Цогтцэций сумруу салдаг уулзварт байрлуулсан.	Үйл ажиллагааны зардлаас	1-р улиралд
6	Аюултай хог хаягдлыг нийлүүлэгч тал болон эрх бүхий байгууллагад буцаан хүргүүлэх, нийлүүлэх	Тосны сав, Аккумулятор	Төслийн үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдал болох хаягдал аккумулятор, тосны хаягдал бочкийг аюултай хог хаягдал хүлээн авах эрх бүхий “Түмэн эгшиг” ХХК-тай 2023 оны 06 сарын 26-нд хийсэн ба аккумулятор, хаягдал бочкануудыг хүргүүлэхээр хуулийн шаардлагад нийцүүлэн тусгай талбайд хадгалж	Үйл ажиллагааны зардлаас	Уурхайн үйл ажиллагаа а үргэлжилж байх үед

		байна.	
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг			2,200

10.1. Нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах

Тайлант хугацаанд уурхайн зам талбайд тархсан хог хаягдлын цэвэрлэгээг бүх хэлтэс нэгжүүд хуваарийн дагуу 7 хоног бүрийн Бямба гаригт бүрт нийт 41 удаа хийсэн байна. Нийт 85.3м3 хог зайлуулсан байна.



Зураг 103.1.1. Бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулж буй байдал

10.2. Хуванцарын хог хаягдлыг ангилан ялгах

Ажилчдын хотхон, засварын шоп, оффисийн өрөөнүүд, уулын хэсэгт паркийн талбай, түлш олгох хэсэгт хог хаягдлыг ангилан хийх өнгөний код, тэмдэглэгээтэй савнуудыг байршуулсан. Хогийн саванд хуримтлагдсан ангилагдсан хог хаягдлыг тус тусад уутлан хуванцар, картон, гялгар уут зэрэг дахивар хог хаягдлыг гэрээт “Дүүрэн Цэций” ХХК-ийн дахивар авах цэгт тухай бүрт тогтмол нийлүүлж байна.

Тайлант хугацаанд нийт 151.5 м³ хуванцрыг гэрээт компаниар дамжуулан дахин боловсуулах үйлдвэрт хүргүүлсэн байна.



Зураг 10.2.1. Ажилчдын хотхоны хог хаягдал түр хадгалах цэгийн сайжруулалт



Зураг 10.2.2. Хуванцар хаягдлыг хүлээлгэн өгөхийн өмнө

10.3. Хаягдал тосыг шаардлага хангасан нөхцөлд цуглуулж, эрх бүхий байгууллагад шилжүүлэх

Техникийн засвар үйлчилгээнээс гарсан хаягдал тосыг Баруун наран уурхайн баруун, зүүн уурхайн аюултай хог хаягдлын нэгдсэн цэгт хуримтлуулж байна. Сав 2/3 хэмжээнд хүрсэн үед эрх бүхий гэрээт байгууллага “Түмэн Эгшиг” ХХК-ийн зориулалтын машинаар тээвэрлэсэн байна. Нийт 17,8 тонн тосыг 2 удаа энэ цэгээс тээвэрлэлт хийгдсэн байна. Тайлант оны 5 сард хаягдал тос цуглуулах емкость байрлуулсан ба үүнээс хойш гарсан хаягдал тосыг нөөцлүүрт түр хадгалж байна.



Зураг 10.4.3.1. Хаягдал тос хуримтлуулах сав ба соруулж байгаа байдал



Зураг 10.5.3.2. Хаягдал тос нийлүүлэгчрүү буцаасан баримтжуулалт

10.4. Аюултай хог хаягдлыг хадгалах талбайг тохижуулж сайжруулах

Аюултай хог хаягдал хадгалах талбайн тохижилтыг тайлант оны 5-р сард хийж гүйцэтгэсэн бөгөөд тус талбайд 25 тонны хаягдал тос хуримтлуулах нөөцлүүр, мөн аюултай хаягдал түр хадгалах 40тн контейнерыг байрлуулж асгаралт үүсэх болон хур тунадасны усаар угаагдан бохирдол тархахаас сэргийлсэн хөмсгийг хийсэн.

Тус цэгийг компанийн дотоод журамд заасны дагуу хаягжуулж аюулгүй байдлыг хангах тэмдэг тэмдэглэгээг хийсэн.



Зураг 10.4.1. Аюултай хог хаягдлыг талбайг тохижуулж байгаа байдал

10.5. Хог хаягдлын чиглэлээр сургалт зохион байгуулах

Хог хаягдлын дотоод журмын агуулгаар уул, засвар, кемпийн ажилчдад сургалт, сэдэвчилсэн яриг 15 удаа хийсэн ба 409 ажилтан хамрагдсан.

“Хог хаягдлыг ангилан ялгаж хэвшье” уриалга бүхий сурталчилгааны зурагт хуудас бэлтгэн нийт ажилчдад тарааж өгсөн.

Олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор хог хаягдлыг зүй зохистой хаях талаарх мэдээллийн самбар хийж, Улаанбаатар- Өмнөговь чиглэлийн төв замын Цогтцэций сумруу салдаг уулзварт байрлуулсан.



Зураг 10.5.1. Хог хаягдлын талаар сургалтанд хамрагдаж байгаа байдал



Зураг 10.5.2. Хог хаягдлын самбар байрлуулсан байдал ба сургалтын бүртгэл


10.6. Аюултай хог хаягдлыг нийлүүлэгч тал болон эрх бүхий байгууллагад буцаан хүргүүлэх, нийлүүлэх

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдал болох хаягдал аккумулятор, тосны хаягдал бочкийг аюултай хог хаягдал хүлээн авах гэрээг эрх бүхий байгууллага болох “Түмэн эгшиг” ХХК-тай 2023 оны 06 сарын 26-нд байгуулсан.

Аккумулятор, хаягдал бочкануудыг эрх бүхий байгууллагад хүргүүлэх хүртэл хугацаанд хуулийн шаардлагад нийцүүлэн тусгай талбайд хадгалж байна.



Зураг 10.6.1. Хаягдал аккумулятор, тосны бочкануудыг тусгай талбайд цуглуулан хадгалж байгаа



Зураг 10.6.2. Аюултай хог хаягдлын гэрээ

11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
1	Байгаль орчны хууль, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор дотоод хяналтыг хэрэгжүүлэх	Баруун наран төсөл	Баруун наран уурхайд 9-р сард дотоодын хяналтыг нийцлийн нэгжээс хийсэн ба олборлолтын гэрээт компаниуд дотоод хяналтыг мөн тогтмол зохион байгуулдаг. Түүнчлэн сар бүр ажлын байрны үзлэг хийгдэж байгаа бөгөөд 2023 онд 34 байгаль орчны үл тохирол илэрсэн ба залруулах арга хэмжээний гүйцэтгэл 100 хувьтай байна.	1,000.0	Ажлын байрны үзлэгийн хариу арга хэмжээний гүйцэтгэл 100% байна.

2	Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдэд сургалт, мэдээллийн ажил зохион байгуулах	Баруун наран төсөл	Дэлхийн цэвэр агаарын өдрийг тохиолдуулан Ханхонгор сумын ерөнхий боловсролын сургуулийн 3-10 дугаар ангийн сурагчдад дотоод орчны агаарын бохирдол, түүнээс урьдчилан сэргийлэхэд бидний оролцоо болон тасалгааны цэцгийн ач холбогдол, арчилгаа сэдвийн дор товч танилцуулгыг хийв. Сургалтын үеэр эко клубыг цэцэгжүүлэх ажлыг зохион байгуулав. Танилцуулга арга хэмжээнд 100 - аад сурагч 3 багш хамрагдсан. Түүнчлэн сургуулийн цэцэрлэгт хүрээлэнд тоорой мод, хайлаас модыг багш сурагчидтай хамтран тарив.	3,350.0	Тэмдэглэлт өдрийг 2 удаа зохион байгуулсан. 1. Дэлхийн усны өдөр 2. Дэлхийн цэвэр агаарын өдөр
3	Ус ашигласны төлбөрийг ноогдуулалтын дагуу төлж барагдуулах ажилд хяналт тавих	Баруун наран төсөл	Ус ашигласны төлбөрийг хуулийн хугацаанд тухай бүр төлж байгаа болно.	Үйл ажиллагааны зардал	Байгаль орчны хууль эрх зүйн хүрээнд
4	Байгаль орчны төлөвлөгөөт аудит хийлгэх	Баруун наран төсөл	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох шаардлагын дагуу БН төслийн байгаль орчны хууль эрх зүйн нийцлийн 2 жил тутмын аудитыг хийлгэх ээлжит хугацаа 2023 онд таарч байгаа бөгөөд тус ажлыг гүйцэтгүүлэхээр аудитын эрх бүхий мэргэжлийн байгууллага болох БОАД ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.	Үйл ажиллагааны зардал	
5	Уурхайн БОННУ-д нэмэлт тодотгол хийлгэх	Баруун наран төсөл	Хуулийн шаардлагын хүрээнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх ажлыг хийлгэхээр мэргэжлийн байгууллага болох “Эх Монголын байгаль” ХХК-тай гэрээ байгуулах шатанд явагдаж байна.	Үйл ажиллагааны зардал	Баруун наран уурхайн ТЭЗҮ шинэчлэгдэхтэй холбоотой
БОМТ-ний зардал, мян.төг				4,350.0	

11.1. Байгаль орчны дотоод хяналт

Энержи ресурс ХХК-ийн Байгаль орчин хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн, нийцлийн алба нь компанийн дотоод хяналт хийх журмын дагуу жилдээ 1 удаа дотоод хяналтыг зохион байгуулан ажилладаг.

Уг ажлын хүрээнд Баруун наран уурхайн үндсэн гэрээт компаниудад өөрсдийн гаргасан хяналтын хуудсаар үндсэн ажиллагааг шалгах болон байгаль орчны хяналтын хуудсаар хяналтыг 9-р сард дотоод хяналтыг доорхи шалгах хуудсын дагуу хийсэн.

1. Шатахуун түгээх станц, агуулахын байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас
2. Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас
3. Үйлдвэр, агуулахын барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас
4. Хэмжүүр, хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдлыг шалгах хяналтын хуудас

Энэхүү дотоод хяналтаар илэрсэн үл тохирлыг залруулах арилгах төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Түүнчлэн тус уурхайн олборлолтын гэрээт компани нь 2023 онд дотоод хяналт шалгалтын ажлыг өөрийн үйл ажиллагаандаа уялдуулан Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Усны тухай хууль гэх гол 3 хуулинд нийцлийн үнэлгээг 6 дугаар сард дотооддоо хийсэн ба, 6 үл нийцэл илрүүлж залруулах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж хариу арга хэмжээг авч ажиллаж байна.

КАТЛАВ: "ЮУ ЭЙ АР ИН" ХХК-НИЙ ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Б.МЯГМАРНУЭВ

2023 ОНД ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭХ ХУУДАМЖ

НӨГ. ҮНДЭСЭЛЭЛ

1. Засгийн газрын 311-р тогтоолын хүрэгжлтийг хангах
2. Компанийн Ерөнхий захирлын тушаалаар баталсан "Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах тухай журам"-ийг үндэслэн.

ХОЁР. ЗОРИЛГО

Дотоод хяналт шалгалтын ажлын жилийн төлөвлөгөөний дагуу байгууллагын үйл ажиллагаа, үүрэгж байгаа ажлыг үйлчилгээг нь хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, иргэн тушаалтны болон өөрийн гаргасан шийдвэрт нийцж байгаа эсэхэд аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд хяналт тавих илэрхий үл нийцэл, дутагдлыг арилгах эрх зүйн баримт бичгийн бүрдлийн нийцлийг хангах, баталгаажуулах.

ГУРАВ. ХАМАРАХ ХҮРЭЭ

"Юу ЭЙ Ар Ин" ХХК-ийн үйл ажиллагаанд хамраал хэсэг нэгжүүд доторх зуулийн дагуу хамрагдана. Үүнд:

- Ни уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Усны тухай хууль
- Хог хаягдлын тухай хууль

КАТЛАВ: "ЮУ ЭЙ АР ИН" ХХК-НИЙ ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Б.МЯГМАРНУЭВ


2023 ОНД ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭХ ХУУДАМЖ

№	Хяналтын үндэслэл тухай	Тусгай зөвлө	Үл нийцэл илэрчээ байгаа	Төлөвлөгөө	Төлөвлөгөөний арга хэмжээ	Дуусгах өдөр	Төлөвлөгөөний ажлын	Дотоод хяналтын ажлын
1	1. Шатахуун түгээх станц	ХАГААРГА	NO	1.1.1. Шатахуун түгээх станц, агуулахын байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хуудас	Шатахуун түгээх станц, агуулахын байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хуудас	2023.02.01	Төлөвлөгөө хангаж	Хяналт
2	2. Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	ХАГААРГА	NO	1.1.2. Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг шалгах хуудас	Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг шалгах хуудас	2023.02.01	NO хяналт	Хяналт
3	3. Үйлдвэр, агуулахын барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас	ХАГААРГА	NO	1.1.3. Үйлдвэр, агуулахын барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг шалгах хуудас	Үйлдвэр, агуулахын барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг шалгах хуудас	2023.02.01	NO хяналт	Хяналт
4	4. Хэмжүүр, хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдлыг шалгах хяналтын хуудас	ХАГААРГА	NO	1.1.4. Хэмжүүр, хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдлыг шалгах хуудас	Хэмжүүр, хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдлыг шалгах хуудас	2023.02.01	NO хяналт	Хяналт
5	5. Шатахуун түгээх станц	ХАГААРГА	NO	1.1.5. Шатахуун түгээх станц, агуулахын байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хуудас	Шатахуун түгээх станц, агуулахын байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хуудас	2023.02.01	Төлөвлөгөө хангаж	Хяналт
6	6. Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	ХАГААРГА	NO	1.1.6. Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг шалгах хуудас	Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг шалгах хуудас	2023.02.01	Төлөвлөгөө хангаж	Хяналт

2023 ОНД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ҮЛ НИЙЦЛИЙГ ЗАЛРУУЛАХ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭХ

№	Хяналтын үндэслэл тухай	Тусгай зөвлө	Үл нийцэл илэрчээ байгаа	Дотоод хяналт, шалгалтын ажлын гүйцэтгэх хуудамж	Дуусгах өдөр	Хяналтын ажлын гүйцэтгэх хуудамж	Дотоод хяналтын ажлын гүйцэтгэх хуудамж	2023.06.25		2023.07.25		2023.08.25		2023.09.25		2023.10.25	
								Туслах	Хэрэгжүүлж байна	Туслах	Хэрэгжүүлж байна	Туслах	Хэрэгжүүлж байна	Туслах	Хэрэгжүүлж байна	Туслах	Хэрэгжүүлж байна
1	1. Шатахуун түгээх станц	ХАГААРГА	NO	1.1.1. Шатахуун түгээх станц, агуулахын байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хуудас	2023.02.01	Төлөвлөгөө хангаж	Тамга	100%	NO	NO	Төлөвлөгөө хангаж	Тамга	100%	NO	NO	NO	NO
2	2. Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	ХАГААРГА	NO	1.1.2. Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг шалгах хуудас	2023.02.01	NO хяналт	Хэсэг ажлын үндэслэл	100%	NO	NO	Төлөвлөгөө хангаж	Тамга	100%	NO	NO	NO	NO
3	3. Үйлдвэр, агуулахын барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас	ХАГААРГА	NO	1.1.3. Үйлдвэр, агуулахын барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг шалгах хуудас	2023.02.01	NO хяналт	Хэсэг ажлын үндэслэл	100%	NO	NO	Төлөвлөгөө хангаж	Тамга	100%	NO	NO	NO	NO
4	4. Хэмжүүр, хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдлыг шалгах хяналтын хуудас	ХАГААРГА	NO	1.1.4. Хэмжүүр, хэмжих хэрэгслийн хэмжлийн нэгдмэл байдлыг шалгах хуудас	2023.02.01	NO хяналт	Хэсэг ажлын үндэслэл	100%	NO	NO	Төлөвлөгөө хангаж	Тамга	100%	NO	NO	NO	NO
5	5. Шатахуун түгээх станц	ХАГААРГА	NO	1.1.5. Шатахуун түгээх станц, агуулахын байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хуудас	2023.02.01	Төлөвлөгөө хангаж	Тамга	100%	NO	NO	Төлөвлөгөө хангаж	Тамга	100%	NO	NO	NO	NO
6	6. Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас	ХАГААРГА	NO	1.1.6. Шатахуун түгээх станцын үйл ажиллагааг шалгах хуудас	2023.02.01	Төлөвлөгөө хангаж	Тамга	100%	NO	NO	Төлөвлөгөө хангаж	Тамга	100%	NO	NO	NO	NO

Зураг 11.1.1. Дотоод хяналтын үзлэгийн хуудас болон үл тохирлыг залруулах төлөвлөгөө



Зураг 11.1.2. Дотоод хяналт хийгдэж байгаа нь

Түүнчлэн сар бүр ажлын байрны үзлэг хийгдэж байгаа бөгөөд 2023 онд 34 байгаль орчны үл тохирол илэрсэн ба залруулах арга хэмжээний гүйцэтгэл 100 хувьтай байна.

11.2. Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдэд сургалт, мэдээллийн ажил зохион байгуулах

Дэлхийн цэвэр агаарын өдрийг тохиолдуулан “Энержи Ресурс” ХХК болон Баруун наран уурхайн гэрээт компани болох UARP ХХК-ийн байгаль орчны баг хамтран дараах ажлыг зохион байгуулав. Үүнд:

1. Ханхонгор сумын ерөнхий боловсролын сургуулийн 3-10 дугаар ангийн сурагчдад дотоод орчны агаарын бохирдол, түүнээс урьдчилан сэргийлэхэд бидний оролцоо болон тасалгааны цэцгийн ач холбогдол, арчилгаа сэдвийн дор товч танилцуулгыг хийв. Танилцуулга арга хэмжээнд 100 -аад сурагч 3 багш хамрагдсан ба тус сумын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Бэхбат байлцав.
2. Сургалтын үеэр тус сургуулийн “ Хэрмийн бялзуухай эко клубт 20 ширхэг тасалгааны цэцэг, болон цэцгийн бордоо хүлээлгэн өгсөн ба тус эко клубыг хариуцсан багшид цэцгийн арчилгаа усалгаа болон бордоог ашиглах заавар зөвлөмжийг өгөв.



Зураг 11.2.1. Дотоод орчны агаарын бохирдол, түүнээс урьдчилан сэргийлэх болон багасгах арга хэмжээг сэдвээр ахлах эрүүл ахуйч М. Оюунчимэг танилцуулга хийж буй байдал.

3. Сургуулийн хүсэлтийн дагуу компанийн мод үржүүлгийн талбайд тарьж ургуулсан Тоорой мод болон Хайлаас модны 12ш тарьцыг сургуулийн ногоон байгууламжийн талбайд сургалтанд оролцсон багш сурагчдын хамт тарив.



Зураг 11.2.2. Сургуулийн гаднах цэцэрлэгт тоорой модны суулгац тарьж байгаа нь Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Өмнөговь аймгийн сумдуудын дунд бүсчилсэн Дэвжээ тэмцээнийг “Өөрчлөлтийг хурдасгая” уриан дор Өмнөговь аймгийн БОАЖГ-аас зохион байгуулсан бөгөөд тус тэмцээний төвийн бүсийн хэсгийн шагналын сан болон зохион байгуулах багийн бүрэлдэхүүнд мөнгөн лэмжлэг үзүүлж оролцсон.



Зураг 11.2.3. Дэвжээ тэмцээн зохион байгуулж буй байдал

11.3. Ус ашигласны төлбөрийг ноогдуулалтын дагуу төлж барагдуулах ажилд хяналт тавих

Төслийн үйл ажиллагаанд ашиглах ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах усны дүгнэлт зөвшөөрлийг хуулийн дагуу авч, ус ашигласны төлбөрийг усны ашиглах дүгнэлтийн дагуу улирал тутамд төлж байна.

. Зураг 11.3.1. Усны төлбөр төлсөн баримт

11.4. Байгаль орчны аудит төлөвлөгөөт аудит хийлгэх

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох шаардлагын дагуу БН төслийн байгаль орчны хууль эрх зүйн нийцлийн 2 жил тутмын аудитыг хийлгэх ээлжит хугацаа 2023 онд таарч байгаа бөгөөд тус ажлыг гүйцэтгүүлэхээр аудитын эрх бүхий мэргэжлийн байгууллага болох БОАД ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна.

11.5. Уурхайн БОННУ-д нэмэлт тодотгол хийлгэх

Хуулийн шаардлагын хүрээнд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх ажлыг хийлгэхээр мэргэжлийн байгууллага болох “Эх Монголын байгаль” ХХК гэрээний шатанд явагдаж байна.

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

12.1. Газрын доорхи усны хяналт шинжилгээ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
1	Гар худгуудын усны түвшин болон эрдэжилт, ЦДЧ, рН хэмжих.	Уурхай орчимд байрлах малчдын 4 гар худаг	Хэмжилтийг сар бүр хийсэн	1,200.0	Сар тутамд хэмжилт хийгдсэн байх
2	Малчдын гар худгуудын усны чанарын хяналт.	Уурхай орчимд байрлах малчдын 4 гар худаг	Ухаа худаг уурхайн усны шинжилгээний лабораторит 4 гар худгийн усанд химийн шинжилгээ хийлгэсэн	500.0	Усны ерөнхий химийн шинжилгээ хийлгэсэн байх
3	Ундны усны эх үүсвэрүүдээс дээж авч шинжилгээ хийлгэх	Кемп болон уурхайн 3 цэгт	Ундны усны эх үүсвэрүүдээс дээж авч лабораторийн шинжилгээ хийлгэсэн.	300,0	Жилд 1 удаа шинжилгээ хийлгэсэн байх
Нийт				2,000.0	

12.1.1. Гар худгуудын усны түвшний хэмжилтийн тайлан

Баруун наран уурхайн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд уурхай орчмын малчдын 4 худаг гар худгуудын усны түвшин болон эрдэжилт, ЦДЧ, рН хэмжилтийг 1-10 сарын хооронд 8 удаа нийт 32 удаагийн хээрийн хэмжилтийг хийж, бүртгэл хөтөлсөн.




График 1. Худгийн усны түвшний хэмжилтийн дүн

Малчдын худгуудын усны түвшний хэмжилтийн үр дүнд Богвайн шанд болон Бяцхан ус нь 2023 оны 8 удаагийн хэмжилтээр усны түвшин тогтмол нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Их бууц болон Батжаргалын худгуудын усны түвшин нь 1-р сараас 4-р сар хүртэл харьцангуй тогтвортой байсан бол 5-р сард усны түвшин 0.7 м болон 0.57 м-ээр тус тус нэмэгдсэн үр дүн ажиглагдаж байна. Дараах 2 худгийн түвшин нь 5-р сараас хойш хэлбэлзэл багатай үр дүн ажиглагдаж байна. Бяцханы ус болон Батжаргалын худаг нь эзэн нь тодорхойгүй унд ахуй болон мал усалдаггүй гадны хэрэглээгүй худаг болно.

12.1.2. Малчдын гар худгуудын усны чанарын хяналт

Малчдын гар худгуудын уснаас дээж авч ерөнхий химийн шинжилгээ хийлгэсэн. Шинжилгээний дүнг MNS900:2010 “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага” стандарттай харьцуулан дүнг боловсрууллаа.

Хүснэгт 12.1.2.1. Худгийн усны химийн үзүүлэлтийн шинжилгээний үр дүн

№	Шинжилгээний үзүүлэлтүүд	Стандарт	Богвойн шанд	Батжаргал	Бяцхан ус	Их бууц
1	Өнгө, градус	20	3.91	200	185	3.91
2	ЦДЧ ц/см	1.0	0.96	0.46	0.42	0.48
3	Ууссан давс, мг/л	-	482	230	210	241
4	Усны орчин, рН	6.5-8.5	7.90	7.73	7.58	7.60
5	Ерөнхий хатуулаг, мг-экв/л	7	2.18	4.18	4.48	5.20
6	Аммоны ион (NN4), мг/л	1.5	0.79	≤0.05	1.54	≤0.05
7	Нитритийн ион (NO2), мг/л	1	0.031	0.099	0.022	0.018
8	Фторид (F), мг/л	≤0.05	≤0.05	≤0.05	≤0.05	≤0.05
9	Нийт төмөр (Fe), мг/л	0.3	0.05	1.20	0.28	0.05

MNS0900:2018 “Ундны ус, эрүүл ахуйн шаардлага” стандартаас хэтэрсэн үзүүлэлтүүдийг дээрх хүснэгтэнд улаанаар тэмдэглэв.

Шинжилгээний дүнгээс харахад Батжаргалын худгаас дээж авахад ус нь шар өнгөтэй, ойр орчмын хөрсөнд олон жил хадгалагдсан өтөг бууц их зэрэг нь газар гэсэх болон хур тунадасны улмаас худгийн усруу орсон байна. Иймээс шим бохирдолоос үүсэлтэй өнгө, нийт төмөр, болон нитритийн ионы хэмжээ их гарсан байна. Бусад 2 худгийн усны шинжилгээний дүн стандартын хэмжээнд байна.

12.1.3. Ундны усны эх үүсвэрүүдээс дээж авч шинжилгээ хийлгэх

Баруун наран уурхайн унд ахуйн ашигладаг 2 худгийн уснаас авч итгэмжлэгдсэн АЛС лабортаорит микроэлементийн шинжилгээг хийлгэсэн.

Хүснэгт 12.1.3.1. Ундны усны шинжилгээний үр дүн

Элементүүд	Al	As	Ba	Cd	Cr	Cu	Fe	Mn	Mo	Pb	Sb	Sr	V	Zn	Ni
MNS6148:2010	0.5	0.01	2	0.003	0.07	1	0.3	0.1	0.04	0.05	0.006	-	5	0.3	0.01
Кэмийн худаг	0.02	<0.01	<0.01	<0.01	<0.01	<0.01	0.02	0.01	0.03	0.02	<0.04	0.77	0.01	0.30	0.03
Засварын худаг	0.01	<0.01	0.01	<0.01	<0.01	<0.01	0.02	0.05	0.01	<0.02	<0.04	3.00	<0.01	0.03	<0.01

Ундны усны микроэлементийн шинжилгээний үр дүнг MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах, Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ стандарттай харьцуулан үзэхэд стандартаас хэтэрсэн үзүүлэлт ажиглагдахгүй байна.

12.2. Агаарын чанарын хяналт шинжилгээ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян. төг	Биелэлтийн шалгуур
1	Уурхайгаас нарийн тоосыг зорилгоор үүсэх ширхэгт хянах PM 2.5	Уурхай орчимд байрлах 3	Хэмжилтийг сар бүр хийсэн	1,400.0	Сар тутамд хэмжилт хийгдсэн байх

	хэмжээтэй тоосонцорын концентрацийг тодорхойлох				
2	Ухаа Худаг уурхай болон НАБТ орчмын гадаад орчны агаарын чанарын \ NO ₂ , SO ₂ , хэмжилт хийх .	Уурхай Ажилчдын хотхон ШТС	Дотоодын итгэмжлэгдсэн багажаар хэмжилтийг 3 цэг дээр хийж гүйцэтгэсэн	1,200.0	Хөндлөнгийн хяналт хийлгэсэн байх
Нийт				2,600.0	

12.2.1. Гадаад орчны тоосны концентрацийн хэмжилт

Уурхайгаас гарах нарийн ширхэгт тоосыг хянах зорилгоор PM 2,5 хэмжээтэй тоосонцорын концентрацийг тодорхойлж Баруун наран уурхайд байнгын 3 цэгт тоосонцорын хэмжилтийг 1 цагийн хугацаатайгаар нийт 21 хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Хэмжилтийн үр дүнг MNS 4585:2016 “Агаарын чан ар, техникийн ерөнхий шаардлага” Монгол улсын стандарттай харьцуулан дүгнэлт гаргасан.




График 2. Баруун Наран уурхайн тоосны концентрацийн хэмжилтийн үр дүн

Дээрх графикаас харахад PM 2.5 нарийн ширхэглэгт тоосонцорын хэмжилтийн үр дүнд 403 болон 404 пост дээр 1-р сард стандартаас 0.126 мг/м³, 0.106 мг/м³-ээр тус тус хэтэрсэн, 5-р сард стандартаас 0.045 мг/м³, 0.139 мг/м³-ээр тус тус хэтэрсэн үзүүлэлтэй байна. Баруун Наран 402 постны хувьд 6-р сард стандартаас 0.016 мг/м³ хэтэрсэн үзүүлэлт ажиглагдаж байна.

Тоосны концентрацийн утга стандартаас өндөр гарсан тохиолдлууд нь хүйтний улиралд уурхайн зам усалгаа аюулгүй байдлын шалтгаанаар хязгаарлагддаг болон хаврын улиралд салхины хүч нэмэгдэж, шороон шуургатай өдрүүдийн тоо нэмэгддэг нь үндсэн суурь нөхцөл болох талтай.

12.2.2. Гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээ

Гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээний хүрээнд бохирдуулагч хий болох азотын давхар исэл, хүхрийн давхар исэл, нүүрсхүчлийн хий, хүхэрт устөрөгчийг хэмжилтийг дотоодын хөдөлмөрийн эрүүл ахуйн gas tester II H in polybutel багажаар NO₂, SO₂, CO₂ түбэ, хүхэрт ус төрөгчийг Drager X-am 5000 багаж ашиглан хийсэн. Агаарын чанарын хэмжилтийн уурхай орчмын 6 цэгт хийсэн болно.



Зураг 12.2.2.1 Хэмжилт хийж буй байдал

Хүснэгт 12.2.2.1. Агаарын шинжилгээний дүн, мкг/м³

Цэгийн нэр үзүүлэлт	Агаарын чанарын MNS4585:2016 стандарт	Уурхай	Шатахуун түгээх станц	Ажилчдын хотхон
Хүхэрлэг хий SO ₂ , мкг/м ³	450 мкг/м ³	123.92 мкг/м ³	442.69 мкг/м ³	114.68 мкг/м ³
Азотын давхар исэл мкг/м ³	200 мкг/м ³	115.39 мкг/м ³	52.02 мкг/м ³	37.48 мкг/м ³
Нүүрсхүчлийн хий CO ₂	1800 мг/м ³	Илрээгүй		
Хүхэрт устөрөгч		Илрээгүй		

Дээрх дүнгүүдээс харахад азотын давхар исэл, хүхрийн давхар ислийн хэмжилтийн дүнг агаарын чанарын MNS4585:2016 стандарттай харьцуулахад бүх хэсэгт стандартаас хэтэрсэн үзүүлэлт ажиглагдахгүй байна.

12.3. Хөрсний судалгаа

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур
1	Баруун наран уурхай болон дэд бүтцийн барилга байгууламж орчмын хөрснөөс микро элементийн дээж авч шинжлүүлэх	Баруун наран уурхай орчим цэг Засварын төв, ШТС, Хогийн цэг хяналтын 1 цэг	Итгэмжлэгдсэн хөрсний шинжилгээний лабораторит жилд 1 удаа шинжлүүлсэн	600.0	Жилд 1 удаа шинжилгээ хийлгэсэн
2	Хөрсний агрохимийн шинжилгээ	Шимт хөрсний овоолгууд	Итгэмжлэгдсэн хөрсний шинжилгээний лабораторит жилд 1 удаа шинжлүүлсэн	400.0	Жилд 1 удаа шинжилгээ хийлгэсэн
Нийт				1000.0	

12.3.1. Хөрсний микро элементийн шинжилгээ

Баруун наран уурхайн хөрсний бохирдлыг хянах зорилгоор 4 цэгээс дээж авч АЛС хөрсний итгэмжлэгдсэн лабораторит шинжилгээ хийлгэсэн.

Хүснэгт 12.3.1.1. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн

№	Байршил	Pb	Cd	Hg	As	Cr	Sr	V	Cu	Ni	Co	Zn	B
	MNS 5850:2019	100	3	2	6	150	800	150	100	150	50	300	25

1	Ажилчдын хотхон	10	<0.5	<1	7	24	39	44	21	18	7	49	10
2	Засварын төв	21	<0.5	<1	8	23	233	29	106	22	13	138	20
3	Харьцуулах цэг	10	<0.5	<1	8	25	38	43	24	20	9	53	10
4	Шатахуун түгээх станц	16	<0.5	<1	12	38	78	58	38	26	12	71	10
5	Хогийн цэг	12	<0.5	<1	13	35	153	23	35	21	15	65	10

Баруун наран уурхай болон дэд бүтцийн барилга байгууламж орчмын 4 цэгийн хөрснөөс микро элементийн шинжилгээ өгсөн.

Шинжилгээний дүнгээс харахад Хүнцэл, Хар тугалга Зэсээс бусад элементийн агууламж MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заагдсан хэмжээнд байна. Засварын төв дээр дээр стандартад заагдсан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс зэс 6 мг/кг-аар өндөр агууламжтай гарсан байна. Зэсийн агууламж 2020 онд 46 мг/кг, 2021 онд 54 мг/кг, 2022 онд 29 мг/кг тус тус байсан ба 2023 оны зэсийн агууламж өмнөх 3 онтой харьцуулахад 2-3 дахин их гарсан байна. Харин хүнцэлийн (As) агууламж нь Баруун нарангийн 4 цэг дээр стандартад заагдсан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс 1-3 дахин өндөр агууламжтай гарсан байна.

Энэ нь говийн бүс нутгийн газрын гадаргын эрдэс чулуулгийн бүтэц найрлагын онцлогтой холбогдон тайлбарлагдах бөгөөд энэ талаар хийсэн эрдэмтдийн судалгаа шинжилгээний бүтээл цөөнгүй байдаг.

12.3.2. Хөрсний агрохимийн шинжилгээ

Баруун наран уурхайн шимт хөрсний овоолгын 10 цэгээс 2023 онд дээж авч хөрсний агрохимийн шинжилгээг “Инженер геофизи ХХК”-д хийлгэсэн.

Хүснэгт 12.3.2.1. Хөрсний агрохимийн шинжилгээний дүн

Дээжний нэр		Шимт хөрсний овоолго 2016	Шимт хөрсний овоолго 2018	Шимт хөрсний овоолго 2019	Шимт хөрсний овоолго 2020	Шимт хөрсний овоолго 2022	Шимт хөрсний овоолго 2023
pH		9.15	8.73	9.55	9.79	9.06	9.09
ЦДЧ dsm		0.297	0.223	0.169	0.520	0.984	0.309
Давс %		0.13	0.10	0.08	0.24	0.45	0.14
Ялзмаг %		0.65	0.56	0.29	0.17	0.92	0.17
CaCO ₂ %		1.32	0.82	0.82	1.32	1.15	0.99
Шингээгдсэн сууринд, мг-экв/100 гр	Ca	8.8	8.4	11.1	5.2	10.4	11.6
	Mg	0.2	2.4	9.7	7.0	5.5	2.4
Шимт гэжээлийн элементүүд, мг/100 гр	P ₂ O ₅	1.8	1.6	2.2	1.2	2.2	2.3
	K ₂ O	15	13	44	48	48	26

Шинжилгээний үр дүнг 2022 оны шинжилгээний үр дүнтэй харьцуулан үзэхэд pH, ЦДЧ үзүүлэлтүүд харьцангуй зөрүү багатай байсан. Хөрсний үржил шим тэжээлийн гол үзүүлэлт нь хөрсний ялзмаг байдаг бөгөөд шимт хөрсний ялзмаг нь 2023 оны үзүүлэлтээс 0.12-0.75%-аар их байгаа нь шимт хөрсний ялзмагын алдагдал бага байгааг харуулж байна. Бусад үзүүлэлтийн хувьд харьцангуй өөрчлөлт багатай байгаа нь ажиглагдаж байна.

Хүснэгт 12.3.2.2. Баруун наран уурхайн шимт хөрсний овоолгын механик бүрэлдэхүүн

Дээжний нэр		Шимт хөрсний овоолго 2016	Шимт хөрсний овоолго 2018	Шимт хөрсний овоолго 2019	Шимт хөрсний овоолго 2020	Шимт хөрсний овоолго 2022	Шимт хөрсний овоолго 2023
Механик ширхэгүүд %, ширхэгийн хэмжээ, Мм	1-0.25	31.9	43.5	27.4	26.2	19.3	26.5
	0.25-0.05	49.2	38.5	42.1	46.7	40.4	40.3
	0.05-0.01	4.4	3.6	18.1	12.0	19.8	19.7
	0.01-0.005	4.2	5.3	3.2	2.9	4.1	0.9
	0.005-0.001	7.7	7.7	2.1	6.9	10.1	9.3
	<0.001	2.6	1.4	7.1	5.3	6.3	3.3
	<0.01	14.5	14.4	12.5	15.1	20.5	13.5

Хөрсний механик бүрэлдэхүүн нь 2 мм-ээс жижиг ширхэгтэй элс, тоос, шавар гэсэн хатуу хэсгүүдийн харьцаагаар илэрхийлэгдэх бөгөөд эдгээрээс аль фракц нь зонхилж байгаагаас хамаарч тухайн хөрсний механик бүрэлдэхүүний нэршил хамаардаг. Элсний ширхгийн хэмжээ 2-0.05мм, тоосных 0.05-0.002мм, шаварных <0.002мм тус тус байдаг (“Guidelines for soil description”. 2006). Судалгааны үр дүнгээс харахад хөрсөн дэх элсэн фракцын утгийн хэлбэлзэл буюу 1-0.05 мм-д 49.5% - 71.6% байсан. Тоосны фракцын утгийн хэлбэлзэл буюу 0.05-0.01 мм-ийн хооронд 3.1% - 17.3% байна. Шаврын фракцын утгийн хэлбэлзэл буюу 0.01-0.001 мм-ийн хооронд 4.7% - 11.7% байсан. Дээрх графикийн үзүүлэлтээс харахад хөрсний механик бүрэлдэхүүний ихэнх хувийг элсэн фракц 1-0.05 мм эзэлж байгааг харуулж байгаа ба харин тоос болон шаварлаг бүтэц нь харьцангуй бага байгааг харуулж байна.

12.4. Ургамал, Амьтны аймгийн судалгаа

№	Хяналт шинжилгээний төрөл	Хамрах хүрээ	Ажлын гүйцэтгэл	Нийт зардал, төг	Тоо хэмжээ
1	Ургамлын аймгийн судалгаа хийх	Их уул	Ургамлын бүрхэцийн судалгааг мониторингийн цэгт Раменскийн торыг ашиглан хийж гүйцэтгэв. Мөн бичиглэлийн үзүүлэлтүүдийг мэдээллийн санд бүртгэн авч 2020, 2021, 2022 оны бичиглэлтэй харьцуулалт хийж тайланд оруулав.	-	3 цэг
2	Амьтны судалгаа хийлгэх	Их уул	Зэрлэг амьтны судалгааг БОННУ-ний хүрээнд мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд “Эх монголын байгаль” ХХК-тай гэрээ байгуулсан байна. Судалгааны ажил хийгдэхээр хүлээгдаж байна.	-	1 цэг
Нийт				5,600.0	

12.4.1 Ургамлын бүрхэвчийн судалгаа

Бид, ажлын даалгаварт заагдсан тодорхой цэгүүдэд мониторингийн бичиглэл хийж ургамалжилтын доройтлын түвшнийг илэрхийлэх, нөхөн сэргээсэн талбайд үнэлэлт өгөх зорилгоор ургамлын бүлгэмдэл үүсгэлт, зонхилох зүйл, ургамлын тусгагийн бүрхэц, нэг цэгт бүртгэгдэх зүйлийн тоо, зүйлийн бүрэлдэхүүний амьдралын хэлбэрийн онцлог, доройтлыг илэрхийлэгч зүйлүүдийн эзлэх хувь зэргийг тодорхойлох зорилт тавин ажилласан. Баруун Наран уурхай орчимд ургамалжилтын мониторингийн 4 цэгт бичиглэл хийж боловсруулахад Ахар навчит баглуурт, Таанат гэсэн 2 бүлгэмдэлд нийтдээ 9 зүйл бичиглэлд хамрагдсан.



Зураг 12.4.1.1. Баруун Наран уурхайн хойд BNSF04



Зураг 12.4.1.2. Баруун Наран уурхайн хойд (BNSF03), Баг хуш хамхаг (*Halogeton glomeratus*)

Хүснэгт 12.4.1.1. Баруун Наран уурхай орчмын ургамлын нөмрөгт бүлгэмдэл үүсгэлт, зүйлийн бүрэлдэхүүн

Баруун Наран уурхай			Урд	Зүүн	Баруун	Хойд
Бичиглэлийн код		Амьдралын хэлбэр (Raunkiaer, 1934)	BNSF01	BNSF02	BNSF04	BNSF03
Өндөршил (м)			1504.2	1483.5	1497.2	1518.5
Өргөрөг (N)			43.590630	43.581400	43.587870	43.599380
Уртраг (E)			105.228040	1015.191950	105.222710	105.215870
Өвслөг ташингын (H) бүрхэц (%)			30	20	40	22
Зонхилогч зүйл (H)			<i>Anabasis brevifolia</i>			<i>Allium polyrhizum</i>
Зүйлийн тоо			4	4	5	5
Зүйлийн шинжлэх ухааны нэр	Зүйлийн монгол нэр					
<i>Anabasis brevifolia</i> C.A.Mey	Ахар навчит баглуур		H	2b	2b	3
<i>Allium mongolicum</i> Regel	Монгол сонгино, хөмөл		G	2m		
<i>Allium polyrhizum</i> Turcz. ex Regel	Таана, Баглагар сонгино	G	1	1	2a	2a
<i>Halogeton glomeratus</i> (M.Bieb.) Ledeb.	Баг хуш хамхаг	T	1	+	1	1
<i>Reaumuria songarica</i> (Pall.) Maxim.	Зүүнгарын улаан бударгана	H		2m	2m	
<i>Krascheninnikovia ceratoides</i> (L.) Gueldenst.	Орог тэсэг	Ch				2m
<i>Stipa glareosa</i> P.A.Smirn.	Сайрын хялгана	H				1
<i>Grubovia dasyphylla</i> (Fisch. & C.A.Mey.) Freitag & G.Kadereit	Үст манан хамхаг	T				+
<i>Puccinellia tenuiflora</i> (Griseb.) Scribn. & Merr.	Турьхан цэцэгт зурман сүүл	T			1	

Товчилсон үгийн тайлбар: P: Фанерофит; Ch: Хамефит; G: Крпифит; H: Гемокрпифит; T: Терофит

Баруун наран, орчимд ургамлын тусгагийн бүрхэц маш бага (дундаж 30%), зүйлийн бүрдлийн тоо цөөн (дундаж 4-5 зүйл), тэдгээрийн дотор терофитүүд тодорхой хувийг эзэлж, мөн доройтлыг илэрхийлэгч зүйлүүд (Турьхан цэцэгт зурман сүүл *Puccinellia tenuiflora*; Харлаг үмхий өвс *Reganum*

nigellastrum; Амманы сэдэргэнэ Convolvulus ammannii) илэрч бүлгэмдэлд давамгайлсан тархалттай бүртгэгдсэн нь уурхай орчмын ургамлын нөмрөг ихээхэн доройтолтой болохыг илтгэж байна.

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагаа	Тайлан мэдээлэл хүлээн авах тал	Гүйцэтгэл	Биелэлтийн шалгуур
1	Багийн иргэдийн нийтийн хуралд оролцож мэдээлэл өгөх	Ханхонгор сумын Хондот баг	Энэ оны 6 сарын 19 болон 9-р сарын 29-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Хондот багийн нийтийн хурлын үеэр Баруун наран уурхайн үйл ажиллагаа болон орон нутгийн харилцаа хамтын ажиллагааны талаарх танилцуулгыг хийсэн.	Багийн нийтийн хурал зохион байгуулагдах үед
2	Орчны хяналт шинжилгээний ажлын танилцуулга, үр дүнг танилцуулах	Ханхонгор сумын иргэд	Тайлант онд хамтын оролцоот орчны хяналт шинжилгээний ажлыг 9 сарын 17 өдөр зохион байгуулж 12 иргэнийг хамруулсан болно.	Жилд 1 удаа
3	Аюултай хог хаягдлын тайлан	Ханхонгор сумын ЗДТГ-г	Баруун наран уурхайн аюултай хог хаягдлын жилийн эцсийн тайланг Хог хаягдал улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэхийн журамд заагдсан хуулийн хугацаанд холбогдох байгууллагууд руу хүргүүлэхээр ажиллаж байна.	Жилд 1 удаа

13.1. Багийн иргэдийн нийтийн хуралд оролцож мэдээлэл өгөх

Ханхонгор сумын Хондот багийн 1,2-р улирлын иргэдийн нийтийн хуралд компанийн удирдлага, орон нутгийн харилцаа болон байгаль орчны ажилтнууд оролцож Баруун наран уурхайн үйл ажиллагаа болон орон нутгийн харьцаа хамтын ажиллагаа, байгаль орчны чиглэлээр танилцуулгыг хийсэн.



Зураг 13.1.1. Хондот багийн хуралд танилцуулга хийж буй байдал

Хурлын үеэр нэг малчин өрхүүдээс ирсэн санал хүсэлтийн дагуу 4 өрхөд 490ш мод, мод усалгааны 2ш сав, мод услах мото помп, хашаа, бордоо зэрэг дэмжлэгийг үзүүлж мод тарих талаар зөвлөмж өгч санал хүсэлтийг шийдвэрлэж ажиллав.

13.2. Орчны хяналт шинжилгээний ажлын танилцуулга, үр дүнг танилцуулах сумын иргэдэд танилцуулах

Баруун наран уурхайн удирдах ажилтнууд, байгаль орчны хэсэг болон Орон нутгийн харилцааны нэгжүүд хамтран байгаль орчны хээрийн хэмжилтийн ажилд иргэдийг оролцуулж хэмжилтийн бодитой мэдээллийг иргэдэд олгох зорилготой ажлыг жил бүр зохион байгуулдаг хамтын оролцоот орчны хяналт шинжилгээний ажлыг 9 сарын 17 өдөр зохион байгуулж 12 иргэнийг хамруулсан болно.



Зураг 13.1.4. Малчин өрхүүдэд мэдээлэл хийх үеийн зураг

Баруун наран уурхайн хувьд нөлөөллийн худгийн хэмжилтийг “Богвайн шанд” малчны гар худаг дээр /мал услахаас өмнө/ хийсэн. Хэмжилтээр тус худгийн усны түвшин 0.75м, усны эрдэсжилтийн хэмжээ 593 мг/л, рН буюу усны орчин 8.26 зэрэг үзүүлэлтүүдийг усны хэмжилтийн зөөврийн багажны тусламжтайгаар хийж холбогдох дүр дүнг оролцогчдод танилцуулав. Тухайн худгийн хувьд усны түвшний хэмжээ өмнөх жилүүдийн тухайн сарын үзүүлэлттэй харьцуулахад усны түвшин харьцангуй өөрчлөлт багатай байна. Харин тоосны хэмжилтийг Баруун наран уурхайн оффисын гадна талбайд хийж хэмжилтийн багажны танилцуулга болон хэмжилтийн үр дүнг танилцуулав. Хэмжилтийн үр дүнгээс үзэхэд тоосжилтын хэмжээ нь 0.006 мг/м³ буюу байсан нь Монгол улсын агаарын чанарын MNS 4585:2016 стандартаас бага үзүүлэлттэй байсан.



Зураг 13.1.5. Орон нутгийн иргэдийг мониторингид оролцуулж буй байдал.

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТӨСВИЙН ЗАДАРГАА

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төлөвлөсөн зардал 36,55 сая төгрөг бөгөөд түүний барьцаа болох 15.0 сая төгрөгийг Төрийн сангийн тусгай дансанд Хангад Эксплорэйшн компаниас байгаль орчин хамгаалах төлөвлөгөөний барьцаа болгон шинээр байршуулсан болно.

№	Хийгдэх ажлын чиглэл	Хийгдсэн ажлын тодорхойлолт	Зарцуулалт, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	Уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	6,300.00 Үйлдвэрлэлийн зардлаас
2	Нөхөн сэргээлт	Мод сөөг тарьж ургуулах	Тэр бум модны төсөвөөс
		Мод сөөг үржүүлэх, ногоон байгууламжийн усалгаа арчилгаа, мод тарих	3,000.00
3	Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа	Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	7,500.0 Үйлдвэрлэлийн зардлаас
4	Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор	Нөлөөллийн бүсийн малчид болон сумдын иргэдэд өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх	ОНХ-н зардлаас
5	Түүх соёлын өвийг хамгаалах	Ажил төлөвлөгдөөгүй	-
6	Осол эрсдэлийн менежмент	ХАБЭА БО-ны сургалт зохион байгуулах, Гамшгаас хамгаалах ба Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж ажиллах	2,000.0
7	Хог хаягдлын менежмент	Хог хаягдлын ангилан ялгалтын нэр төрлийг нэмэгдүүлэх, хог хаягдал түр хадгалах цэгийг сайжруулах,	2,200.0
8	Удирдлага зохион байгуулалт	Байгаль орчны дотоод хяналтыг зохион байгуулах, Газрын хянан баталгаа, Сургалт мэдээлэл	4,350.0
9	Орчны хяналт шинжилгээ	Усны хяналт шинжилгээ	2,000.0
		Агаарын чанарын хяналт шинжилгээ	2,600.0
		Хөрсний хяналт шинжилгээ	1,000.0
		Ургамлан бүрхэвчийн судалгаа	5,600.0
10	Олон нийтэд тайлагнах	Мониторингийн ажилд олон нийтийг оролцуулах, төрийн байгууллагад мэдээ тайлан хүргүүлэх	-
НИЙТ ЗАРДАЛ, мян.төг			36,550.0